



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/151

Булган сум

Аймгийн өсвөрийн шигшээ багийн
дасгалжуулагчдын хамтран ажиллах
гэрээг шинэчлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2024 оны IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн өсвөрийн шигшээ багийн самбо, жүдо бөхийн дасгалжуулагч Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Ш.Эрдэнэ-Очир, сагсан бөмбөгийн дасгалжуулагч спортын дэд мастер Б.Мөнх-Ирээдүй, Боксын дасгалжуулагч Д.Мөнхболд нарын хөлсөөр ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, хамтран ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Х.Батхишиг)-т даалгасугай.

2. Багш, дасгалжуулагчдын үндсэн цалинг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

